

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
дарын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

БҮС, ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН БОДЛОГО ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
Х.ДЭЛГЭРДАЛАЙГИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Биелэлт	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
			1	2			
Зорилт 1. “Газар олголтыг эрчимжүүлж, төв суурин газрын бодлогын бичиг баримтыг боловсруулах”							
1.1	Газар ашиглалт, эзэмшилт, өмчлөлтийн ажлыг жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу зохион байгуулна.	Ашиглалт, эзэмшилт, өмчлөлтийн хувь	24 сум, 15%	24 сум, 15.2%	Газар зохион байгуулалтын ажил Монгол Улсын Засгийн газрын мэдэлд очиж цахимаар хийгддэг болсон. Завхан аймгийн 24 сумаас Улиастай, Тосонцэнгэл, Отгон, Алдрхаан 4 сум хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй. ХЕТ-тэй сумдын газар ашиглалт, эзэмшилт, өмчлөлт хийгдэж байна. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгүй сумдад газар зохион байгуулалтын ажил хийгдэхгүй болсон.	2025.01.01 - 2025.12.31	30
1.2	Сум суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулна.	Төлөвлөгөө хийгдсэн сумдын тоо	4 сум, 16.6%	10 сум, 41.6%	Тэс, Түдэвтэй, Шилгүүстэй, Их-Уул, Идэр 5 сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажилд ОНТ-өөс 740.0 сая, Сантмаргаз, Ургамал, Сонгино, Тэлмэн 4 сумд сум хөгжүүлэх сангаас 525.0 сая төгрөгөөр хөгжлийн	2025.01.10 - 2025.12.25	100

				ерөнхий төлөвлөгөө боловсруулах санхүүжилтийг шийдвэрлүүлсэн. Дээрхи 9 сумын хөржлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зургийн даалгаварыг боловсруулсан. Гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендер худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу тендерийг зарлуулсан.		
--	--	--	--	---	--	--

Зорилт 2. “Барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх”

2.1	Он дамнан баригдаж байгаа байгууламжийн ажлыг эхлүүлж, батлагдсан санхүүжилтэд ажлыг угсралтын ажлыг хийлгэнэ.	Барилга байгууламжийн тоо, ажлын гүйцэтгэл	10-50%	30-50%	Он дамнан баригдаж байгаа 25 барилга байгууламжаас Нөмрөг сумын Соёлын төв, Асгат сумын дотуур байр, Завханмандал сумын сум дундын амбулаторийн барилга, нийт 3 барилгын санхүүжилт улсын төсөвт шийдвэрлэгдээгүй тул гэрээ сунгаж, ажил эхлэх боломжгүй болсон. Бусад 22 барилга байгууламжийн угсралтын ажлын гэрээ, ажлын гүйцэтгэлд хяналт шалгалт хийж, 2025 оны 05 сард барилга угсралтын ажлууд эхэлсэн хийгдэж байна.	2025.04.15 - 2025.12.15	90
2.2	Засвар шинэчлэлт хийгдэх байгууламжийн ажлыг хийлгэнэ.	Барилга байгууламжийн тоо, ажлын гүйцэтгэл	00%	10-50%	Засвар шинэчлэлт хийгдэх 8 барилга байгууламжийн засварын ажлын зураг төсөл, ажлын тоо хэмжээг гаргаж, гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерийг ХАА-ны төлөвлөгөөний дагуу зарлуулсан. Улиастай сумын 50 ортой төрөх тасгийн барилгын гүйцэтгэгчээр “Жавхлантур” ХХК шалгарсан, ажил гүйцэтгэх гэрээ хийгдээгүй хүлээгдэж байна. Бусад 6 барилга байгууламжийн засварын ажил төлөвлөгөөний дагуу	2025.01.01 - 2025.12.15	100

					хугацаандаа хийгдэж байна. Япон улсын “Өвсний үндэс” төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр Их-Уул сумын хүн эмнэлгийн барилгын засварын ажил 90%-тай хийгдэж байна.		
2.3	Шинээр эхлэн баригдах барилга байгууламжийн ажлыг эхлүүлнэ.	Барилга байгууламжийн тоо, ажлын гүйцэтгэл	00%	00-30%	Шинээр эхлэн баригдах 5 барилга байгууламжийн зураг төсөл, ажлын тоо хэмжээг хийлгэж, гүйцэтгэчийг сонгон шалгаруулах төндөрийг зарлуулах холбогдох зураг төсөв, ажлын тоо хэмжээг гаргаж, холбогдох газруудад хүргүүлсэн. 2025 онд Улсын төсөвт батлагдсан Улиастай хотын 3-р цэцэрлэгийн 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга нь хүчин чадал зөрүүтэй 200 хүүхдийн цэцэрлэг гэж санхүүжилт батлагдсан. Дамнаас дахин 200 хүүхдийн цэцэрлэг болгож зураг төсөл хийлгэх шаардлагатай гэсэн боловч одоо байгаа газар дээр 200 хүүхдийн цэцэрлэг багтахгүй, орон нутаг 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын зураг төсөл хийлгэж хүргүүлсэн байхад яагаад 200 хүүхдийн цэцэрлэгийн барилга болж санхүүжилт батлагдсан талаар маргаан гарч төндөр зарлах боломжгүй болоод байна.	2025.01.01 - 2025.12.15	90
2.4	Инженерийн шугам сүлжээ бүхий орон сууц барих төслүүдийг дэмжиж, Улиастай хотын орон сууцны хорооллын	Орон сууцны тоо	1210	1310	2025 оны 02 сард Улиастай сумын Жинст багт 95 айл, Богдын гол багт 20, 25 айлын орон сууцны барилгуудыг ашиглалтанд оруулсан. Улиастай хотын “21-р зуун орон сууцны хороолол”-ын барилга	2025.04.10 - 2025.12.31	100

барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.			угсралтын ажлыг эхлүүлэх, танилцуулга, мэдээллийг бэлтгэж 2 удаа зөвлөлийн хуралд оруулсан. Орон сууцны корпораци байгуулах судалгаа, шинжилгээг хийсэн.		
-----------------------------------	--	--	--	--	--

Зорилт 3. “Хуулиар олгогдсон эрх үүргийг хэрэгжүүлэх”

3.1	Шинээр баригдах болон засвар шинэчлэлт хийх барилга байгууламжийн зураг төслийг хийлгэж, хяналт хийнэ.	Зураг төсвийн тоо, ажлын гүйцэтгэл	00%	00-50%	8-н барилга байгууламжийн зураг төсөл, инженер геологийн дүгнэлтийг хийлгэж 86.4 сая төгрөгийн урьдчилгаа санхүүжилтийг шилжүүлсэн. Улиастай сумын Чигэстэй, Өлзийт багудын халуун усны барилга, Богдын голын 2км үерийн далангийн төсөв шинэчлэх, Завхан их сургуулийн барилгын засвар, Тосонцэнгэл сумын 2-р цэцэрлэг, Ургамал сумын сургуулийн барилга, Тэлмэн сумын дотуур байрны барилгуудын зураг төсвийг хийлгэж байна.	2025.01.01 - 2025.12.15	100
-----	--	------------------------------------	-----	--------	--	-------------------------	-----

Зорилт 4. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах”

4.1	Өргөдөл, гомдол, хүсэлт, хариутай бичгийг хугацаанд шийдвэрлэнэ.	Тоо, хугацаа	00%	100%	2025 оны хагас жилийн байдлаар 76 албан бичиг цахимгаар ирсэнээс 66 албан бичиг шийдвэрлэж, 10 бичгийн хугацаа болоогүй судлагдаж байна. Хугацаа хоцорч ирсэн 1 бичиг ирсэн. Барилгын халаалттай холбоотой 1 өргөдөл, гомдол ирсэн тул 1 өргөдөл, гомдлыг хугацаанд нь шийдвэрлэж хариуг өгсөн.	2025.01.01 - 2025.12.31	100
4.2	Дэд салбаруудтай холбоотой тайлан, мэдээг хугацаанд нь холбогдох газруудад хүргүүлнэ.	Тайлан 2, мэдээ 10 хэрэгжилт, хугацаа	00%	100%	2025 оны хагас жилийн байдлаар ХЕБСОСЯам, БХТөв, ГЗБГЗЗЕГ, БШУЯ, СЯ зэрэг газруудад барилга байгууламжийн ажлын явцын мэдээг улирал бүр, сарын ажлын мэдээ, тогтоол шийдвэр, 3Г-ын үйл	2025.01.01 - 2025.12.31	100

				ажиллагааны хөтөлбөр, ЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг тайлан мэдээг хуваарийн дагуу хугацаанд нь гаргаж хүргүүлсэн. Хугацаа хоцорсон тайлан, мэдээ байхгүй.		
--	--	--	--	--	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Салбарын сургалтанд 2-оос доошгүй удаа сууж мэдлэг чадвараа дээшлүүлнэ.		-	100%	2025.01.24-29-ний өдрийн хооронд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалт яамнаас зохион байгуулсан “Хот олон талт төлөвлөлт, тогтвортой хөгжил” сэдэвт сургалтанд хамрагдсан.	2025.01.01 - 2025.12.31	100
2	Шинээр гарсан норм дүрэм, зураг төсөл, төсвийн программ хангамж судлаж, суралцана.	Норм дүрэм, программ хангамжийн тоо	-	100%	Сүүлийн 4 жилийн хугацаанд барилга байгууламжийн норм дүрэм, программ хангамж жил бүр шинэчлэгдэн өөрчлөгдөж байгаа тул чөлөөт цагаар цахимаар байнгын суралцан судлаж байна.	2025.01.01 - 2025.12.31	100

ТАЙЛАН БИЧСЭН:

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын бодлого хариуцсан мэргэжилтэн (Албан тушаал)

Х.Дэлгэрдалай /  / (Нэр, гарын үсэг)

2025.06.16 (Огноо)